

**БООМТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭМБЭРЭЛИЙН ЗОРИГООГИЙН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь		
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)						
			1	2	3	4	5				
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх”											
1.	Хилийн боомтын хүчин чадал нэмэгдэж, албан хаагчдын амьдрах орчин нөхцөл хангагдсан байдал	Хэрэгжилт хувиар	80%	1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын 2-р ээлжийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ. Гүйцэтгэл 90%. 2.Бичигт боомтын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд төслийн нэгжтэй хамтран ажиллана. 3.Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна.	1. Алтанбулаг боомтын Бүтээн байгуулалтын ажил 2025 оны 04-р сард эхэлсэн. Гүйцэтгэл 97%. ГЕГ-ын ажлын хэсэг 2025.04.21-ний өдөр ажлын хэсэг бүтээн байгуулалтын ажлын явцтай танилцсан. Бүтээн байгуулалтын ажлын явцын талаар RIBS төсөл, гүйцэтгэгч “Монкон констракшн” ХХК-тай мэдээлэл солилцон, дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Шалган нэвтрүүлэх барилгын ажлын гүйцэтгэл 97%-тай, 2025 оны 6-р сард багтаан дуусгахаар урьдчилан төлөвлөсөн байна. 2. Бичигт хилийн боомтод ГЕГ-ын ажлын хэсэг албан томилолтоор ажиллаж, бүтээн байгуулалтын төслийн хүрээнд баригдаж буй барилга байгууламжийн ажил бүрэн зогссон, гүйцэтгэл жигд бус, газар шорооны ажлууд дуусаагүй, автозамын ажил замын түвшин жигд бус, мөн ажил нь бүрэн зогссон байдалтай газар дээр нь танилцаж, төслийн нэгжтэй мэдээлэл солилцож хамтран ажилласан. RIBS төслийн нэгж,	2025.01.01-2025.06.10					

			<p>4. Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтыг эхлүүлэх, барилгын ажлын явцад төслийн нэгжтэй хамтран хяналт тавина.</p>	<p>Хяналтын зөвлөх компанийн зүгээс гүйцэтгэгчид өгсөн удаа дараагийн шаардлагын дагуу арга хэмжээ авч ажиллаагүй, гэрээний болон барилгын хуулийг зөрчсөн тул гэрээ цуцлах саналыг захиалагчаас АХБ-нд хүргүүлсэн.</p> <p>3. АХБ-ны зээлийн хөрөнгө оруулалтачар “Хилийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой худалдааг дэмжих төсөл”-ийн дэд төсөл болох Хавирга хилийн боомтын өргөттөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын худалдан ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус боомтын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан барилга байгууламж, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, тавилгын судалгааг холбогдох чиглэл хариуцсан нэгжүүдээс саналыг авч нэгтгэн Бoomтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албанад 2025.06.04-ний өдрийн 01-3.1/2369 тоот албан бичгээр хүргүүлсэн. ТХАГ-ын даргын тушаалаар Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах батлагдсан шалгуурыг АХБ-нд хүргүүлсэн. Барилгын чанарын хяналтын зөвлөх компаний сонгон шалгаруулалтын 1-р үе шат явагдаж дууссан бөгөөд 98%-ийн гүйцэтгэлтэй байна.</p> <p>4. Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын 1-р үе шатанд баригдах</p>	
--	--	--	---	--	--

					барилга, байгууламж, хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг сонгон холбогдох саналыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан. Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын 1-р үе шатанд баригдах барилга, байгууламжийн ажлын төлөвлөлт, хугацааны графикийг ирүүлэх талаар 2025.06.02-ны өдрийн 01/3.1/2318 тоот албан бичгийг "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц" төслийн нэгжид хүргүүлсэн. Бэлтгэл ажлыг хангах талаар "Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц" төслийн ИТА-тай зөвшилцсэн. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймгаас боомтын 2-р үе шатны бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт эцэслэн шийдвэрлэгдээгүй байна. Монголын тал 2-р үе шатны бүтээн байгуулалтын зам барилгын байгууламжийг барих 2 компанийг шалгаруулсан байна.		
2.	Боомтын хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг тесөл боловсруулалт	Хэрэгжилт хувиар	80%	1.Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын 1-р үе шатанд баригдах барилга, байгууламж, хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн саналыг төслийн нэгжтэй хамтран баталгаажуулна; 2.Бага-Илэнх боомтын ажлын зурагт барилга	1. ГЕГ болон Хөгжлийн хөтөч-Дэд бүтэц төслийн нэгжтэй хамтарсан хурал 2025.02.04 өдөр хийж, Цагаандэл уул боомтын бүтээн байгуулалтын 1-р үе шатанд баригдах барилга, байгууламж, хяналт шалгалтын тоног төхөөрөмжийг сонгон холбогдох саналыг хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан. Хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл, бараа, материал, тоног төхөөрөмжийн жагсаалт, ажлын нарийвчилсан календарьчилсан графикийг Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн нэгжээс ГЕГ-д ирүүлэхээр талууд зөвшилцсэн.	2025.01.01-2025.06.10	

				байгууламж, тоног төхөөрөмжийн байршил, тоо хэмжээ зэрэг холбогдох саналыг тусгуулна.	2. Бага-Илэнх боомтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах ажлын гүйцэтгэгч "Ди Ди Эй Жи" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу ГЕГ-ын ХБГ, ХЦХ-тэй хамтран 2025.01.29-ний өдөр уулзалт зохион байгуулж шаардлагатай мэдээллийг өгсөн. Гүйцэтгэгчээс эхлэлийн тайлан, байгаль орчны үнэлгээний тайланг 2025.02.20-ны өдөр Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн бөгөөд БХТ, ЭЗХЯ-аар хянагдаж 2025.03.21-ний өдөр баталгаажсан. Зураг төслийн ажлын гүйцэтгэл 50%.		
3.	Байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог хангаж ажилласан байдал	Хэрэгжилт хувиар	70%	1.Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд төслийн нэгж, гүйцэтгэгч, ашиглагч байгууллагатай хамтран ажиллана. 2.Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, саналыг АХБ-нд хүргүүлнэ.	1. Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын 2-р ээлжийн барилгын ажил 2025 оны 04-р сард эхэлсэн. Бүтээн байгуулалтын ажлын явцын талаар RIBS төсөл, гүйцэтгэгч "Монкон констракшн" ХХК-тай мэдээлэл солилцон, дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан. Бүтээн байгуулалтын шалган нэвтрүүлэх барилгын ажлын гүйцэтгэл 97%-тай, 6-р сард багтаан дуусгахаар урьдчилан төлөвлөсөн байна. 2. ТХАГ-ын даргын тушаалаар Хавирга боомтын бүтээн байгуулалтын гүйцэтгэгч болон захиалагчийн хяналтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах батлагдсан шалгуурыг АХБ-нд хүргүүлсэн. АХБ-ны зээлийн хөрөнгө оруулалтаар "Хилийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой худалдааг дэмжих төсөл"-ийн дэд	2025.01.01 2025.06.10	

				төсөл болох Хавирга хилийн боомтын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын худалдан ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд тус боомтын батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд өөрчлөлт оруулахтай холбогдуулан барилга байгууламж, хяналт шалгалтын тоног төхөөрөмж, тавилгын судалгааг холбогдох чиглэл хариуцсан нэгжүүдээс саналыг авч нэгтгэн Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны ажлын албанад 2025.06.04-ний өдрийн 01-3.1/2369 тоот албан бичгээр хүргүүлсэн.	
4.	Хөрш оронтой хилийн боомтын шинэчлэлт, бүтээн байгуулалтын асуудлаар хамtran ажилласан байдал	Хэрэгжилт хувиар	100%	<p>Боомтын сэргэлтийн Үндэсний хороо, Хилийн боомтын захиргаа, болон бусад хөрш оронтой хийх хурал уулзалтаар боомтын төлөвлөлтийг уялдуулах асуудлыг хэлэлцүүлж, мэдээлэл солилцсон байна.</p> <p>1. Монгол Улсын Хилийн боомтын захиргаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Боомтын албан хоорондын хамтын ажиллагааны 2025 оны 1-р улирлын уулзалт 2025.02.25-28-ны өдөр зохион байгуулагдсан. Тус уулзалтаар хэлэлцэх асуудлын санал болон 2, 3-р улирлын уулзалтын протоколын хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж ХБЗ-нд 2025.01.29-ний өдрийн 02-463 тоот албан бичгээр хүргүүлсэн. Уулзалтаар хилийн боомтоор нэвтрүүлэх бараа, зорчигчийн мэдээлэл, хилээр нэвтрүүлэх тусдаа гарц байгуулах, хилийн голд үерийн далан байгуулах зэрэг асуудлуудыг хэлэлцүүлсэн. Талуудын ажлын хэсгийн 2024 оны 2, 3 дугаар улирлын уулзалтаар хэлэлцэн тохирсон ажлын хэрэгжилт, хурсэн үр дүн, цаашдын хамтын</p>	2025.01.01 2025.06.10

		<p>ажиллагааны талаарх мэдээллийг ГЕГ-ын даргад илтгэх хуудсаар танилцуулсан.</p> <p>2. Монгол Улсын Хилийн боомтын захиргаа, БНХАУ-ын ӨМӨЗО-ын Боомтын албан хоорондын хамтын ажиллагааны 2025 оны 1-р улирлын уулзалтын протоколын хэрэгжилтийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Хилийн боомтын захиргаа болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захиргааны албатай хамтарсан уулзалтаад оролцсон. Тус уулзалтаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хилийн голд байршуулсан хашааг буулгах, үерийн далан байгуулах асуудлыг хэлэлцсэн бөгөөд хятадын талаас боомт орчмын газар зүйн байрлалд судалгаа хийж, хуримтлагдсан усыг татуургаар сорон холдуулах замаар үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхээр зураг төслийг боловсруулж байгаа талаар мэдэгдсэн.</p> <p>3. Монгол Улсын Хилийн боомтын захиргаа, БНХАУ-ын ШУӨЗО-ны Боомтын алба хоорондын хамтын ажиллагааны ажлын хэсгийн уулзалт 2025.05.29-ний өдөр зохион байгуулагдсан. Тус уулзалтаар Бургастай-Лаоемяо, Булган-Такаши肯, Байтаг-Улиастай, Даян-Хуншаньзүй боомтуудаар 8 болон түүнээс доош суудалтай автомашиныг нэвтрүүлэх, Булган-Такаши肯 боомтыг Ням гарагт болон тогтсон баяр амралтын өдрүүдэд ажиллуулах бодит хэрэгцээ шаардлага, 2024 онд нэмэлт цагийн хуваарийн дагуу ажиллуулсан үр дүнгийн талаар хэлэлцсэн.</p>	
--	--	--	--

				Mөн Булган боомтын өргөтгөл шинэчлэлийн бүтээн байгуулалтын хүрээнд хоёр улсын хилийн 126,127 дугаар тэмдгийн чиглэлд ачаа тээврийн хэсгийн авто зам буюу тусгай гарц байгуулах болон Даян боомтын Ямаатын голын гүүрийн бүтээн байгуулалтын талаар санал солилцсон.		
5.	Хилийн боомтод ажиллах албан хаагчдын ажиллаж амьдрах нөхцөл хангагдсан байдал	Хэрэгжилт хувиар	80%	<p>1.Баянхошуу боомтын ухаалаг гарцын байршлыг тодорхойлж, ХБЗ-нд холбогдох мэдээллийг хүргүүлнэ. Сууринуулалтын ажлын явцад хяналт тавина. Гүйцэтгэл 50%.</p> <p>2.Гашуунсухайт боомтын импорт хэсэгт рентген төхөөрөмжийг сууринуулсан байна. Гүйцэтгэл 100%</p> <p>3. Замын-Үүд боомтын ачаа тээврийн экспорт хэсэгт хэсэгт сууринуулах рентген төхөөрөмжийн сууринуулалт 80%.</p>	<p>1. Баянхошуу хилийн боомтод албан томилолтоор ажиллаж, ухаалаг гарц сууринуулахад шаардлагатай техникийн нөхцөл боломжийг судалж байршил, тоо хэмжээ, техникийн тодорхойлолтыг Хилийн боомтын захиргаанд хүргүүлсэн. Хилийн боомтын захиргаанаас гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулсан бөгөөд оролцогч талаас гомдол гаргасан тул хянан шийдвэрлэлтийн үйл явц үргэлжилж байна.</p> <p>2. Гашуунсухайт боомтын ачаа тээврийн импорт хэсэгт рентген төхөөрөмж сууринуулах ажлын зураг тесэл, тесэв баталгаажуулалтын талаар Барилгын хөгжлийн төвд холбогдох тодорхойлолт бүхий албан тоот илгээсэн. Ил далд ажлын актны иж бүрдлийг хянаж, холбогдох үүрэг даалгавар өгсөн. ГЕГ-ын даргын 2025.02.14-ний өдөр баталсан удирдамжийн дагуу ажлын хэсгийг ахлан Гашуунсухайт боомтын ачаа тээврийн импорт хэсэгт ИСБ.А рентген төхөөрөмж сууринуулах ажлыг хүлээн авах техникийн комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, холбогдох үүрэг даалгавар өгсөн бөгөөд</p>	2025.01.01-2025.06.10

		<p>4. Алтанбулаг, Боршоо боомтуудад ачаа тээврийн хэрэгслийн ариутгалын байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан байна.</p> <p>5. Гашуунсухайт боомтын салбар лабораторийн барилгын засварын ажлыг эхлүүлнэ. Гүйцэтгэл 20%</p> <p>6. Хайрхан багт байрлах хил, гаалийн албан хаагчдын 70 айлын орон сууцны тохижилтын ажилд ХБЗ-тай хамтран ажиллана.</p> <p>7. Ханги боомтын уурын зуух, дулаан, цэвэр усны шугам сүлжээний шинэчлэлийн ажлыг эхлүүлнэ. Ажлын гүйцэтгэлд хяналт тавина. Гүйцэтгэл 10%</p> <p>8. Харьяа гаалийн</p>	<p>ГСГГ-аар баталгаажуулан, холбогдох бичиг баримтын бүрдлийг хангуулан, ГЕГ-ын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс ашиглалтад хүлээн авсан. Ашиглалтын нөхцөл байдал хэвийн ажиллаж байгаа талаар ГСГГ-аас мэдээллийг өгсөн.</p> <p>3. Замын-Үүд боомтын ачаа тээврийн экспорт талд рентген төхөөрөмж сууринуулах ИСБ.А" ХХК-ийн туслан гүйцэтгэгч "Араг од" ХХК нь рентген төхөөрөмжийн суурийн ажлыг 2025.03.21-ний өдрөөс эхэлсэн. ГЕГ-ын томилолтын ажлын хэсэг тус боомтод 2025.05.09-10 өдрүүдэд ажиллах үед эрсдэлээс сэргийлэх зорилгоор гүйцэтгэгч талд санал тавьсаны дагуу орох талын рентгений тээврийн хэрэгсэл явах зурваст төмер бетон хязгаарлагч, цацрагийн төхөөрөмж байх хэсэгт босоо төмер бетон хамгаалалт нэмэлтээр хийлгэсэн. Барилгын ажлын бичиг баримт, ил, далд актууд, фото тайланг бүрдлийг хангах чиглэлээр гүйцэтгэгч "Араг од" ХХК-ийн удирдлагад холбогдох үүрэг даалгавар, зөвлөмжийг хүргүүлсэн. ЗҮГГ-д өдөр тутмын хяналт тавих, инженерийн шугам сүлжээний эх үүсвэрийн талаар холбогдох зөвлөмжийг өгч, биелэлтийг хангуулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98%.</p> <p>4. Алтанбулаг боомтын барилгын ажил 90%, Боршоо боомт 60%-ийн гүйцэтгэлтэй. Алтанбулаг, Боршоо боомтуудын ариутгалын байгууламжийн зураг төсөл БХТ-өөр хянагдаж магадлалын нэгдсэн</p>	
--	--	---	--	--

	<p>газар, хороодын цахилгаан хангамжийн эх үүсвэр, ашиглалт, найдвартай ажиллагааг хангах газардуулгын судалгааг хийж, урьдчилсан төсөв, үнийн саналын судалгааг боловсруулсан байна. Гүйцэтгэл 5%.</p> <p>9.Харъяа гаалийн газар, хороо, хилийн боомтуудад 2026 оны улсын төсвийн санхүүжилтээр хийх засварын ажлын саналыг нэгтгэн СХОГ-т хүргүүлнэ.</p>	<p>дүгнэлтүүд гарсан. Барилгын ажлын гүйцэтгэлд өдөр тутмын хяналтыг тавьж ажиллаж байна.</p> <p>5. Гашуунсухайт боомтын салбар лабораторийн засварын ажлын зургийн гүйцэтгэгч “Голомт өргөө” ХХК-тай байгуулсан зургийн гэрээг дүгнэж, акт үйлдсэн. Гүйцэтгэгчээс Гашуунсухайт боомтод 2025.05.03-04 өдрүүдэд ажиллаж, барилга байгууламжийн нөхцөл байдал, хийх ажлын талаар газар дээр холбогдох үзлэгийг ГСГГ-тай хамтран хийсэн. Гаалийн төв лабораторийн удирдлага, гүйцэтгэгч, Хилийн боомтын захиргаатай хамтарсан уулзалтыг 2025.06.06-ны өдөр ГЕГ-т хийж, ажлын төлөвлөгөө, тавигдах шаардлага, үүрэг даалгавар, тодруулгыг гүйцэтгэгчид өгч, хамтран ажилласан. Салбар лабораторийн засварын ажлын зураг, төсвийг магадлалаар орж баталгаажсан. Барилгын засварын ажлын гүйцэтгэл 22%.</p> <p>6. Хайрхан багт байрлах хил, гаалийн албан хаагчдын 70 айлын орон сууцны тохижилтын ажлын гүйцэтгэгч болон ХБЗ-тай хамтарсан уулзалтыг 2025.06.06-ны өдөр ГЕГ-т хийж, ажлын төлөвлөгөө, тавигдах шаардлага, үүрэг даалгавар, тодруулгыг гүйцэтгэгчид өгч, хамтран ажилласан. Мөн ГСГГ-ын удирлагатай гүйцэтгэгчийг холбож өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосон.</p> <p>7. Ханги дахь гаалийн газрын гадна инженерийн шугам сүлжээ, уурын зуухны</p>	
--	--	---	--

				<p>засварын гүйцэтгэгч сонгогдсонтой холбогдуулан, Ханги ГГ-д захиалагчийн техник хяналт болон зохиогчийн хяналтын гэрээ байгуулах, холбогдох төсвийн зардлын зарцуулалтын талаар зөвлөмж өгч, хамтран ажилласан. Дорноговь аймгийн Худалдан авах ажиллагааны газраас сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулсан бөгөөд оролцогч талаас хяналтын байгууллагад гомдол гаргаж хянан шийдвэрлэлтийн үйл явц үргэлжилж байна.</p> <p>8. Харьяа гаалийн газар, хороодод барилга байгууламжуудад тог баригч, тогтвортжуулагч, газардуулга, аянга зайлнуулагчийг суурилуулахад шаардлагатай судалгааг тухайн орон нутгийн аж ахуйн нэгжээр хийлгэж, зураг, төсвийн үнийн саналыг нэгтгэн СХОГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн. 9. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2026 онд харьяа гаалийн газар, хороодын барилга байгууламж, тоног төхөөрөмжид хийх шаардлагатай засварын ажлын саналыг харьяа гаалийн газар, хороодоос албан бичгээр авч нэгтгэж боловсруулж, СХОГ-т дотоод зурвасаар хүргүүлсэн.</p>		
6.	Бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт хувиар	100%	Гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгийн зорилт арга хэмжээний	-Гаалийн байгууллагын 2024 оны “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний биелэлтийг нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд гаргаж ЗҮГ-т хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.10

				хэрэгжилтийг нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд биелэлтийг заасан хугацаанд нь гаргаж холбогдох нэгжид хүргүүлнэ.	-“Монгол улс, БНХАУ-ын Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийн хүрээнд гаалийн байгууллагаас 2024 оны дөрөвдүгээр улиралд хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд гаргаж ЗҮГ-т хүргүүлсэн.		
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт хувиар	100%	Гаалийн байгууллагын хэмжээнд хэрэгжиж байгаа дараах хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийн биелэлтийг нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд гаргаж холбогдох нэгжид хүргүүлсэн байна.	-“Хяналт-Шинжилгээ, Үнэлгээний тайлан хүргүүлэх тухай Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 03/1172 тоот албан бичгээр өгсөн зөвлөмжийн биелэлтийг гаргаж ЗҮГ-т хүргүүлсэн. -Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг нэгжийн чиг үүрэгт хамаарах асуудлын хүрээнд гаргаж заасан хугацаанд нь Хуулийн хэлтэст файлаар хүргүүлсэн. Бусад: - Монгол улсын Татварын багц хуулийн шинэчлэлийн төсөлд Татварын ерөнхий хууль, түүнтэй холбоотойгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Шуудангийн тухай хуульд өөрчлөлт оруулах болон шинээр Гадаад худалдааны тухай хууль батлуулах, мөн Цахим худалдааны талаар гаалийн хяналт бүрдүүлэлт, татвар хураамжийг ногдуулалт, барагдуулалтын чиглэлээр санал бэлтгэн Хуулийн хэлтэст дотоод зурвасаар хүргүүлсэн.	2025.01.01-2025.06.10	
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг	Хэрэгжилт хувиар	100%	-Нэгжийн хүний нөөцийн сул орон тоог нөхөх хэрэгцээ шаардлагыг албан	-Хэлтсийн сул орон тоог нөхөх саналаа албан тушаалтны тодорхойлолтод заасан ерөнхий болон тусгай шаардлагаас гадна тавигдах шаардлагын хамт Хүний нөөцийн	2025.01.01-2025.06.10	

	хэрэгжүүлсэн байдал			тушаалын тодорхойлолтод зассан тавигдах шаардлагын дагуу саналыг боловсруулж Хүний нөөцийн хэлтэст хүргүүлнэ. -Нэгжийн эрсдлийг тухай бүр тооцон эрсдлийн санг тогтмол баяжуулж, эрсдлийг бууруулах арга хэмжээг авна.	хэлтэст 2025.01.06-ны өдрийн 01 тоот дотоод зурвасаар хүргүүлсэн. -Хэлтсийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нэгжийн чиг үүрэгт хамаарах эрсдэл бүхий ажил болох хилийн боомтуудын барилга, байгууламжийн аянга цахилгаанаас урьдчилан сэргийлэх судалгаа, гол түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зохион байгуулалтын ажлуудын төслийг боловсруулсан.		
9.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт хувиар	90%	ГЕГ-ын удирдлага, Захиргааны зөвлөл, мэргэжлийн зөвлөл, шуурхай хуралдаанаас өгсөн зөвлөмж, чиглэл, үүрэг даалгаварыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж тайлагнана.	-ЗУГ-аас 2025.01.13-ны өдрийн 01100/2 тоот дотоод зурвасаар ирүүлсэн чиглэлийн дагуу хэлтсийн албан хаагчдад “Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам”-ыг танилцуулсан. -ГЕГ-т хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаж ЗУГ-т хүргүүлсэн. -Уул уурхайн бүтээгдэхүүний олборлолтыг нэмэгдүүлэх замаар экспортын нэмэлт орлого бүрдүүлэх, гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Сангийн сайдаар ахлуулсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнтэй БХ-ийн дарга Д.Зоригтоо, ХБГ-ын М.Батбилэг нар хамтран Дорноговь аймгийн Ханги хилийн боомтод 2025.03.20-23-ны өдөр албан томилолтоор ажилласан. - ЗДАСП-аар өгөгдсөн ХШУДАГ-ийн 11 зөвлөмж, ЗУГ-ын 1 үүрэг даалгавар, цаг үеийн шинжтэй 2, ТОГ-ын 1 үүрэг даалгавар, нийт 15 зөвлөмж, үүрэг	2025.01.01 2025.06.10	

					даалгаврыг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь гаргаж илгээсэн.		
10.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт хувиар	Хэрэгжилт хувиар	88%	Хэлтсийн албан хаагчдын ажлын цагийг бүртгэж, цаг ашиглалт 90 хувиас дээш байна.	Хэлтсийн нийт албан хаагчид тайлант хугацаанд 448 хүн өдөр ажиллахаас 409 хүн өдөр ажиллаж 33 хүн өдрийн ээлжийн амралттай, 6 хүн өдөр өвчтэй, 0 хүн өдөр чөлөөтэй, ажлын цаг ашиглалт 91.2% хувьтай байна. Тус хэлтэс дарга, ГУАБ -1, ГУБ-3 ажиллаж байгаа бөгөөд ГУБ-2 орон тоо дутуу байна.	2025.01.01-2025.06.10
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт хувиар	Хэрэгжилт хувиар	80%	1.Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос зохион байгуулах хурал, уулзалтаар хэлэлцүүлэх саналыг чиглэл хариуцсан нэгжүүдээс саналыг авч нэгтгэн хүргүүлж, арга хэмжээнд оролцно. Хурал, уулзалтаас гарсан шийдвэр, холбогдох мэдээллийг удирдлагад танилцуулна. 2. Хилийн боомтуудын бүтээн байгуулалтын төсөл арга хэмжээ, үйл ажиллагаа, ажлын цагийн хуваарийн талаарх мэдээллийг	1. Боомтын сэргэлтийн Үндэсний хорооноос зохион байгуулах хурал, уулзалтын саналыг хүргүүлэх, арга хэмжээнд оролцох: -Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Хяналт, бүрдүүлэлтийн газар, Хорио цээрийн хэлтсээс холбогдох асуудлын санал болон эзлжит хуралдаанаар хэлэлцэх асуудлыг саналыг тус тус нэгтгэн 2025.01.20 өдрийн 02/274 тоот албан бичгээр хүргүүлсэн. БСҮХ-ны эзлжит хуралдаанаас гарсан тогтоол, шийдвэрийг хувилан холбогдох гаалийн газрын удирдлагуудад өгсөн. - “Монгол, Хятадын хилийн боомтын менежментийн хамтын ажллагааны комисс”-ын 6-р хуралдааны бэлтгэл ажлын хурээнд протоколын хэрэгжилт болон хэлэлцэх асуудалд оруулах саналыг холбогдох нэгж, дэргэдэх байгууллага болон харьяа гаалийн газар, хороодоос авч нэгтгэн боловсруулж 2025.02.13-ны өдөр	2025.01.01-2025.06.10

		<p>гаалийн байгууллагын цахим хуудаст байршуулахаар холбогдох нэгжид хүргүүлнэ.</p> <p>3. Барилга байгууламж, тоног төхөөрөмж, засварын ажлын худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд болон ГЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллана.</p>	<p>хүргүүлсэн. Хурал 2025 оны 6-р сард зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн.</p> <ul style="list-style-type: none"> - Бoomтын сэргэлтийн Үндэсний хорооны 2025 оны ээлжит 2-р хуралдаанаар хэлэлцүүлэх асуудалд оруулах саналыг ЗББНДБ, харьяа гаалийн газар, хорооноос авч нэгтгэн 2025.03.25 өдөр албан бичгээр хариу хүргүүлсэн. 2. Хилийн боомтуудын үйл ажиллагаа, ажлын цагийн хуваарийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх: -ГХЯ-наас албан бичгээр ирүүлсэн 2025 онд боомтуудын нэмэлт цагийн хуваарийг ЗДАСП-нд байршуулан ГЕГ-ын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодод мэдээллийг хүргэсэн. -Хилийн боомтуудын ажлын цагийн хуваарийг ХХЕГ-ын мэдээлэлд үндэслэн сар бүр гаргаж ОНХА болон байгууллагын 1800-1281 лавлах төвд хүргүүлсэн. -Гаалийн цахим үйлчилгээний систем буюу gaali.mn системд байршуулсан чатботын асуулт, хариултад Монгол Улсын хилийн боомтуудын байршил, ангилал, зэрэглэл, горим, ажлын цагийн хуваарийг оруулахаар мэдээллийг МТГ-т дотоод зурvasaар хүргүүлсэн. 3. Барилга байгууламж, тоног төхөөрөмж, засварын ажлын худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд болон ГЕГ-ын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах: 	
--	--	---	--	--

		<p>3.1 ГЕГ-ын даргын 2024.11.06-ны өдрийн А/605 тоот тушаалаар байгуулагдсан Боршоо боомтын тээврийн хэрэгслийн ариутгал халдвартгүйжүүлэлтийн байгууламж, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулах, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар нар ажиллаж байна. Тайлант хугацаанд ажлын хэсэг гүйцэтгэгч компанийн түншлэлийн төлөөлөл болон зураг төслийн гүйцэтгэгчтэй нийт 5 удаагийн уулзалт, хурал зохион байгуулж зураг төслийг Барилгын хөгжлийн төвөөр хянуулахад шаардлагатай баримт бичгүүдийг гарган өгч хамтран ажилласан. Ажлын хэсгээс боомтуудын ариутгал халдвартгүйжүүлэлтийн байгууламжийн гүйцэтгэгч компанийн түншлэлд зураг төсөл болон барилгын ажлыг эхлүүлэх, гэрээт хугацаанд ажлаа дуусгах, хүлээлгэн өгөх, ажлын график төлөвлөгөө зэрэг мэдээллийг ирүүлэх тухай мэдэгдлийг 2025.03.11-ний 01-3.1/968, 2025.04.07-ны 01-3.1/1378 тоот албан бичгүүдийг хүргүүлсэн. Мөн Алтанбулаг, Боршоо боомтуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж буй бүтээн байгуулалтын ажлыг хилээр нэвтрэх зорчигч, олон нийтэд мэдээлэх, танилцуулах зорилгоор мэдээллийн самбар байршуулах тухай албан бичгийг хүргүүлсэн. Үүний дагуу гүйцэтгэгч компанийн түншлэлээс боомтуудад самбарыг байршуулсан. Алтанбулаг боомтын барилгын ажил 90%, Боршоо боомт 60%-ийн гүйцэтгэлтэй. Алтанбулаг,</p>	
--	--	---	--

		<p>Боршоо боомтуудын ариутгын байгууламжийн зураг төсөл БХТ-өөр хянацдаж магадлалын нэгдсэн дүгнэлтүүд гарсан.</p> <p>4.Бусад ажил:</p> <p>4.1 ЧХОУНБГГ-ын НЦҮТ-ийн барилга байгууламж.</p> <p>Гүйцэтгэгч хилийн 0119-р анги болон ЧХОУНБГГ хамтарсан ажлын хэсэг Хөшигийн хөндийн ЧХОУНБ дахь хилийн хяналтын байгууллагуудын нэгдсэн НЦҮ төвийн барилга байгууламжийн дутуу хийгдсэн ажил болон ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтэл, доголдлыг засварлах ажлыг эцэслэн гаргуулж, холбогдох бичиг баримтаар баталгаажуулсан. НЦҮ-ний төвд сууринуулах цахилгааны нөөц эх үүсвэр буюу дизель генераторийн холбогдох бичиг баримтыг ирүүлсний дагуу шалгахад техникийн нөхцөлд заасан үзүүлэлтийг хангаж байсан.</p> <p>ИНЕГ-тай санхүүжилтийн гэрээ дүгнэсэн актыг ГЕГ-ын дарга, СХОГ-ын дарга, Бoomтын хэлтсийн дарга, Хуулийн хэлтсийн даргын гарын үсгээр тус тус баталгаажуулан ИНЕГ-т хүргүүлсэн. ХХЕГ-ын харьяа хилийн 0119-р анgid нөөц эх үүсвэр буюу дизель генератор шуурхай сууринуулах, ЧХОУНБ дахь гаалийн газрын НЦҮ төвийн барилга байгууламжийн дутуу хийгдсэн ажил болон ашиглалтын явцад үүссэн эвдрэл гэмтэл, доголдлыг засварлах ажлыг төлөвлөх, ашиглалт хариуцсан ЧХОУНБГГ-тай тус тус хамтран ажиллаж, холбогдох зөвлөмж, үүрэг даалгаврыг өгсөн. Барилгын талбайд генератор</p>	
--	--	---	--

байршсан. ГЕГ-аас үлдэгдэл ажил, генератораа бүрэн суурилуулж, ашиглагч ЧХОУНБ дахь гаалийн газарт актаар хүлээлгэн өгснийг үндэслэн холбогдох барьцаа хөрөнгийг чөлөөлөх талаар гүйцэтгэгч хилийн 0119-р ангийн удирдлагад мэдэгдсэн.

4.2 Замын-Үүд боомтын ухаалаг гарцын хаягжуулалт:

Замын-Үүд хилийн боомтод суурилуулах ухаалаг гарцын хаягжуулалтын загварыг холбогдох стандартад нийцүүлэн суурилуулахад шаардагдах төсвийн тооцооллыг ЗҮГГ-тай хамтран хийж, СХОГ-д хүргүүлэн шийдвэрлүүлсэн. Замын-Үүд дэх гаалийн газартай хамтран тус хилийн боомтын ухаалаг гарцын үйл ажиллагаатай уялдуулан ачаа тээврийн орох гарах хэсгийн саравчинд гарц, эгнээ заасан замын тэмдэг тэмдэглэгээг холбогдох стандартад нийцүүлэн мэргэжлийн компаниар хийж гүйцэтгүүлж, суурилуулсан. Холбогдох фото тайланг удирдлагад танилцуулсан.

4.3 Шивээхүрэн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөлд санал тусгуулах:

Шивээхүрэн боомтын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгч "Нарт Дизайн" ХХК-тай 2025.03.24-ний өдрийн 14.00 цагаас уулзалт зохион байгуулсан. Гүйцэтгэгч компаниас боомтын судалгааны ажлын явц болон төлөвлөлтийн шийдлийн талаар танилцуулсан. Тус хурлын шийдвэрийн дагуу боомтын хяналтын бүс, суурьшлын

		<p>бүсэд төлөвлөх барилга байгууламжуудын талаарх саналыг нэгтгэн гүйцэтгэгчид 2025.05.01-ний өдрийн 01-3.1/1804 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>4.4 Гаалийн төв лабораториос Замын-Үүд боомтын салбар лабораторийн барилгын засварын ажлын зураг төсөлд оруулах санал, технологийн байгуулалт, инженерийн шугам сүлжээний өөрчлөлтийг зураг төслийн гүйцэтгэгч "Голомт өргөө" ХХК болон Гаалийн төв лабораторийн дарга С.Цэрэнчимэдтэй зөвшилцэж, баталгаажуулсан. Замын-Үүд боомтын гаалийн салбар лабораторийн барилгын Хaan банкны эзэмшлийн хэсэгт засварын ажил хийхгүй болсонтой холбогдуулан өмнө боловсруулсан зураг төсөл, төсөвт өөрчлөлт оруулах чиглэлээр ЗҮГГ-аас холбогдох зургийн даалгавар ирүүлж, дахин боловсруулалт хийгдэж байна.</p> <p>4.5 Барилгын ажлын гүйцэтгэлийн барьцаа хөрөнгө чөлөөлөх:</p> <ul style="list-style-type: none"> - Замын-Үүд боомтын конторын барилгын засварын ажлын гүйцэтгэгч "Дархан трейд" ХХК-ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх эсэх талаар холбогдох санал ирүүлэх тухай 01-3.1/1607 тоот албан бичгийг ЗҮГГ-д 2025.04.22-ны өдөр хүргүүлсэн. ЗҮГГ-аас гүйцэтгэгч "Дархан трейд" ХХК-д хамаарах барьцаа хөрөнгийг чөлөөлөх тухай саналаа 2025.04.29-ний өдрийн 327 тоот албан бичгээр хариу ирүүлсэн. - Оюутолгой ХХК дахь гаалийн хяналтын бүсэд байрлах салбар лабораторийн барилгын ажлын гүйцэтгэгч Бум констракшн ХХК-ийн барьцаа хөрөнгийг 	
--	--	--	--

чөлөөлөх чиглэлээр Гаалийн төв лаборатори, Хуулийн хэлтэс, Дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсээс холбогдох саналыг авч, барьцаа хөрөнгийг чөлөөлөхгүй талаар 2024.11.18-ны өдрийн 01-1/4770 тоот албан бичгийг "Бум констракшн" ХХК-д хүргүүлсэн. "Бум констракшн" ХХК-ийн барьцаа хөрөнгийг чөлөөлөх боломжгүй талаар ГЕГ-аас 2025.05.23-ний өдрийн 01-1/2177 тоот албан мэдэгдэл хүргүүлсэн. Гүйцэтгэгчээс 2025.05.28-ны өдрийн 22/25 тоот албан бичгээр ГЕГ-ын шийдвэрийг зөвшөөрөхгүй, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх талаар эргэн мэдэгдсэн.

4.6 Хөвсгөл аймгийн Ханх дахь гаалийн хорооноос 2025.04.07-ны өдөр ирүүлсэн 01/61 тоот албан бичиг, холбогдох хавсралт, тус аймгийн ГХБХБГ-өөс гаалийн 8 айлын орон сууцны барилгатай холбоотой гаргасан дүгнэлт, зөвлөмж, албан тоотуудыг үндэслэн ГЕГ-ын 2025.04.18-ны өдрийн 01-1/1505 тоот албан бичгээр холбогдох асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх, тодорхой арга хэмжээ авах чиглэлийг тус гаалийн хороонд хүргүүлсэн.

4.7 Дархан дахь гаалийн газрын дарга Ч.Цэндсүрэн болон гүйцэтгэгчийн удирдлагатай холбогдож, гадна фасадны ажилтай холбоотой үүрэг даалгаврын биелэлтийг шуурхай хангах, холбогдох зөвлөмж өгч ажилласан.

4.8 ГЕГ-ын Налайх дүүргийн Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолбор газрын Буурал Улиастай нэртэй газарт одоо

				<p>байгаа хуучин барилга байгууламжийг буулган, шинэчилж, сургалтын төв болгооор төлөвлөж, үүнтэй холбогдуулан ГЕГ-ын даргын 2024.11.19-ний өдрийн А/616 тоот тушаалын дагуу холбогдох ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсгийн шийдвэрийн дагуу тус Сургалтын төвийн эскиз зураг хийх ажлын үнийн саналыг тодорхойлох зорилгоор нийт 4 барилгын зургийн компанийд 1-3.1/2121 тоот албан бичгийг 2025.05.21-ний өдөр хүргүүлсэн.</p> <p>Үүний дагуу үнэ болон хугацааны саналыг тогтоосон хугацаанд "Кью Эл Скейл" ХХК ирүүлсний дагуу холбогдох санал бүхий албан тоотыг нь ажлын хэсэг болон холбогдох удирдлагад танилцуулсан.</p> <p>4.9 Ховд аймгийн Булган дахь гаалийн газрын салбар лабораторийн барилгын ажлын гүйцэтгэгчтэй холбогдож, буулгалтын ажлын явцын фото тайлангаар үзүүлэх, бараа материал, тоног төхөөрөмжийн талаар зураг зохиогч болон захиалагч талтай зөвшилцөх чиглэлээр холбогдох үүрэг даалгавар, зөвлөмж өгч, хамтран ажилласан. Булган дахь гаалийн газрын удирдлагатай холбогдож, өдөр тутмын хяналт хийх, фото зургаар мэдээлж байхыг мэдэгдсэн.</p>			
--	--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	ГЕГ-ын даргын 2023.03.09-ний	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Гаалийн шинэчлэлийн хүрээнд хэрэгжиж буй	-Гашуунсухайт боомтын ачаа тээврийн импорт хэсэгт рентген	2025.01.01-2025.06.10	

	A/38 дугаар тушаал			гаалийн хяналт шалгалтын “Рентген” иж бүрдэл бүхий тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, хилийн боомтуудын бүтээн байгуулалттай уялдуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах	төхөөрөмж суурилуулах ажлыг хүлээн авах техникийн комиссын бүрэлдэхүүнд ажиллаж, холбогдох үүрэг даалгавар өгч холбогдох бичиг баримтын бүрдлийг хангуулан ашиглалтад хүлээн авсан. Ашиглалтын хэвийн нехцел хангагдсан. -Замын-Үүд боомтын ачаа тээврийн экспорт талд рентген төхөөрөмж суурилуулах ажилд ЗҮГГ-д өдөр тутмын хяналт тавих, инженерийн шугам сүлжээний эх үүсвэрийн талаар холбогдох зөвлөмжийг өгч, биелэлтийг хангуулсан. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 98%.		
2.	Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 111 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн	Хэрэгжилт гүйцэтгэлээр		Монгол улсад олон улсын хуурай боомт байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг судалж санал боловсруулах, гадаад улс, олон улсын байгууллагын дэмжлэг авч, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах	ЗТЯ-ны Хуурай боомтын захиргаанаас БНХАУ-ын хуурай боомтын ложистик төвийн мэдээллийн технологийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж Монгол улс руу тээвэрлэгдэх бараа, тээврийн хэрэгслийн мэдээллийг хурдан шуурхай солилцох талаар уулзалт хийж, гаалийн байгууллагын автоматжуулсан мэдээллийн систем түүний онцлог, нехцел байдлын талаар ярилцсан.	2025.01.01 2025.06.10	
3.	ГЕГ-ын даргын 2024.11.06-ны өдрийн А/606 дугаар тушаалаар	Хэрэгжилт гүйцэтгэлээр	Байгууламжийн барилгын ажил 2024 онд эхэлсэн.	Боршоо боомтын ачаа тээврийн хэрэгслийн ариутгал халдвартгуйжүүлэлтийн байгууламжийн барилгын ажилд хяналт тавин ажиллаж байна. Ажлын	Боршоо боомтын ачаа тээврийн хэрэгслийн ариутгал халдвартгуйжүүлэлтийн байгууламжийн барилгын ажилд хяналт тавин ажиллаж байна. Ажлын	2025.01.01 2025.06.10	

	байгуулагдсан ажлын хэсэгт нарийн бичиг			суурилуулах ажлын гүйцэтгэлд хяналт тавих, хүлээн авах	хэсгээс байгууламжийн зураг төслийг БХТ-өөр хянуулахад шаардлагатай баримт, бичгүүдийг БХТ-д хүргүүлж, гүйцэтгэгчид шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажилласан. Боршоо боомтын ариутгын байгууламжийн зураг төсөл БХТ-өөр хянагдаж магадлалын нэгдсэн дүгнэлт гарсан. Байгууламжийн барилгын ажил 60%-ийн гүйцэтгэлтэй.		
4.	Монгол Улсын сайд, БСҮХ-ны даргын 2025 оны 03 дугаах сарын 11-ний өдрийн А/21 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг			Монгол, Хятадын Замын-Үүд-Эрээн авто замын боомтын ачаа тээврийн хэсгийг 24 цагаар ажиллуулах бэлтгэл ажлыг хангах, цаашид хугацааг сунгах	Zамын-Үүд – Эрээн боомтын ачаа тээврийн хэсгийг 24 цагийн горимд шилжүүлэх бэлтгэл хангах ажлын хүрээнд БНХАУ -ын ӨМӨЗО-ны Боомтын захиргааны албатай хийх уулзалтад оролцсон. Уулзалтаар тус боомтыг уртасгасан цагаар ажиллуулснаар гадаад худалдаа ёсөн нэмэгдэх, улсын хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслийн хурд сайжирч, ачаалал дарааллыг тэнцвэржүүлэн, гадаад худалдаа эрхлэгч нарт учирч буй хүндрэл бэрхшээлийг бууруулах олон талын ач холбогдолтойг хоёр тал онцолж харилцан зөвшөөрсөн бөгөөд хоёр улсын Гадаад харилцааны яаманд уг асуудлыг уламжлахаар болсон.	2025.04.16 2025.04.18	
5.	Монгол Улсын ерөнхий сайдын 2023 оны 136 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт	Хэрэгжилт гүйцэтгэлээр		БНХАУ-ын Үндэсний төмөр замын газраас “Гашуунсухайт-Ганц мод хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих”	Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын нээлтийн үйл ажиллагааны бэлтгэл ажлыг хангах хүрээнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боомтын захиргааны албатай 2025	2025.05.11- 2025.05.15	


					оны 5-р сарын 12-ны өдөр Гашуунсухайт-Ганцмод боомтод газар дээр нь ажиллаж хамтарсан уулзалтад оролцсон. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан тэмэр замын бүтээн байгуулалтын нээлтийн арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан.		
--	--	--	--	--	---	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.	Төрийн худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад хамрагдах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтад хамрагдаагүй.	Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдсан байна.	Тайлант хугацаанд Төрийн худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаагүй болно.	-	-
2.	Шинээр батлагдсан хууль, тогтоомжтой тухай бүр танилцах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орсон хууль, тогтоомжтой танилцсан.	2025 оны 1-р сараас мөрдөгдөж эхлэх хууль тогтоомжтой танилцсан байна.	2025 онд шинээр мөрдөгдөж эхлэх хууль тогтоомжтой танилцсан.	2025.01.01-2025.06.10	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Боомтын хэлтсийн даргын албан ўргийг
түр орлон гүйцэтгэгч
(Албан тушаал)



/Д.Зоригоо /
(Нэр, гарын үсэг)

.....
(Огноо)

**БООМТЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
ДЭМБЭРЭЛИЙН ЗОРИГООГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Бoomтын хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		60,3

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хуртэл оноогоор)
1	Төрийн худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдах.		14,5
2	Шинээр батлагдсан хууль, тогтоомжтой тухай бүр танилцах		14,5
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			14,5

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хуртэл оноогоор)
1	Хандлага, ёс зүй	10
2	Удирдан зохион байгуулах	10
3	Асуудал шийдвэрлэх	10
4	Манлайлах	10
5	Багаар ажиллах	10
6	Харилцаа	10
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7	Мэргэжлийн ур чадвар	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		10

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	60,3
2	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14,5
3	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	10
Нийт оноо= (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		86,8

Үнэлгээ өгсөн:

Гаалийн өрөнхий газрын дарга

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Боомтын хэлтсийн
даргын албан үүргийг
тур орлон гүйцэтгэгч

Төсвийн шууд захирагч

.....(Р.Отгонжаргал)

2025.06.25.....(огноо)

Нэгжийн дарга:

.....(Д.Зоригоо)

2025.06.10.....(огноо)